

2025 оны II улирал

Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын эргэн мэдээлэл




Хянан тохиолдуулсан: ХШҮМХ-ийн дарга Я.Жаргал

Эмхэтгэсэн: Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан ажилтан М.Ганцэцэг




ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2025 ОНЫ II УЛИРАЛ

2025 оны эхний 6 сарын байдлаар Өвөрхангай аймгийн хэмжээнд гэмтэл хордлого, гадны шалтгаант 1475 шинэ тохиолдол бүртгэгдлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.2%-иар өссөн байна.



Осол гэмтлийн шалтгаант өвчлөл хүйсээр




■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Дээрх осол гэмтэлд өртсөн тохиолдлын 69.2% эрэгтэй, 30.8% эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 7 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй байна.



Нийт тохиолдлын 22.3% согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна.


Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал хувиар



■ Согтууруулах ундаа хэрэглэсэн
■ Согтууруулах ундаа хэрэглээгүй




ОСОЛ ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН



Осол гэмтлийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд шат, ор, сандал, цана, чарга, барилга байгууламжаас халтирч тээглэх гэх мэт бүх төрлийн уналтууд нэгдүгээр шалтгааныг эзэлж байгаа бол хоёрдугаарт бүх төрлийн тээврийн хэрэгсэл, явган зорчигч зам тээврийн осолд өртөх болон мориноос унаж гэмтсэн тохиолдлууд, 3 дугаарт спирт /архины хордлого/ болон бусад хий ууранд хордох тохиолдлууд эзэлж байна.


Осол гэмтлийн өвчлөл харьяаллаар 10000 хүн амд

Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг 10000 хүн амд авч үзвэл Арвайхээр, Хархорин, Нарийнтээл, Бүрд, Уянга, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Тарагт сумдад өвчлөл хамгийн их бүртгэгдсэн байна.



Энэ оны эхний 6 сарын хугацаанд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 29.6 хувь нь 0-18 насны хүүхэд бол 70.4 хувь нь насанд хүрэгчид байлаа. Тохиолдлын тоо болон хувиар 10-14, 40-44 насанд осол гэмтэлд хамгийн их өртсөн байна.

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл насны бүлгээр



Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал хүмүүс гэртээ бэртэж гэмтэх тохиолдол хамгийн их буюу 46.9 хувийг эзэлж байна. Дараагаар нь гудамж, зам, хөдөө аж ахуй ферм, биеийн тамир спортын талбай, сургууль цэцэрлэгт байхдаа гэмтэх тохиолдол түгээмэл байна.


Осол гарах үеийн байршил

■ биеийн тамир спортын талбай ■ гудамж, зам ■ гэртээ ■ сургууль, цэцэрлэг ■ хөдөө аж, ахуй ферм




ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2025 II УЛИРАЛ

2025 оны эхний хагас жилийн байдлаар осол гэмтлийн шалтгаант нас баралт бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 38.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Осол гэмтэл гадны шалтгаант нас баралтыг сараар нь авч үзвэл 2, 3 дугаар саруудад хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн ба нийт нас баралтын 45.6 хувийг эзэлж байна.



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 72.7 (32) хувь нь санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байгаа бол, 27.3 (12) хувь нь өөрийгөө болон бусдын амь насанд санаатайгаар гэмтэл учруулсан тохиолдол байна.




Нас барсан нийт тохиолдлын 81.8 хувь нь эрэгтэйчүүд, 18.1 хувь нь эмэгтэйчүүд буюу осол гэмтлийн улмаас амь насаа алдаж буй 10 хүн тутмын 8 нь эрэгтэйчүүд байлаа.

Нас барах үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байдал



Нас баралт хүйсээр




Осол гэмтлийн шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 45.6 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж амь насаа алдсан байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдлыг хүйсээр харвал 100% (371) эрэгтэй, байжээ.



Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтыг насны бүлэг тус бүрд харвал 50-54 насанд 36.3 хувь хамгийн олон тохиолдолтой байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, насны бүлэг, хувиар




ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгааны нэгдүгээрт өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох тохиолдол хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол хоёрдугаарт спиртэд санамсаргүй хордох буюу архины хордлого болон зам тээврийн ослын шалтгаант нас баралт 18.2 хувийг тус тус эзэлж байна.


Санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан нас баралт харьяаллаар



Гадны шалтгаант нас баралтын хамгийн өндөр хувийг эзэлж буй санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан тохиолдлыг харьяаллаар авч үзвэл 10000 хүн амд ноогдох түвшин Уянга суманд хамгийн өндөр буюу 4.4 байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад амиа хорлосон тохиолдол 45.4 хувь, зам тээврийн ослын шалтгаант нас баралт 25 хувиар тус тус өссөн байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан оноор



ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 10000 ХҮН АМД

Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг сум тус бүрээр харвал 10000 хүн амд ногдох нас баралт Уянга, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Баянгол, Богд, Хужирт сумуудад хамгийн өндөр байна.

